



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/907

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “ХОВД-ЗАЛУУ” инженерүүдийн чуулган-2019 арга хэмжээг зохион байгуулахад зориулан 2 720 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 720 000 төгрөг /хоёр сая долоон зуун хорин мянган/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.30-д “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганданповрон нар зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/907 Ch
02 04434

Аймгийн Засаг даргын
2019 оны 12 дугаар сарын 24-ний
өдрийн А/907 дугаар захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

| № | Зардлын нэр | Тоо /ш-р/ | Нэгж үнэ | Нийт |
|---|-----------------------|-----------|----------|-----------|
| 1 | Цэвэр ус | 200 | 800 | 160,000 |
| 2 | Жигнэмэг | 200 | 800 | 160,000 |
| 3 | Бал | 200 | 700 | 140,000 |
| 4 | Дэвтэр | 200 | 4000 | 800,000 |
| 5 | Стэнд /Хөлтэй самбар/ | 4 | 50,000 | 200,000 |
| 6 | Шууд /ТВ/ | 2 | 300,000 | 600,000 |
| 7 | Мандат | 200 | 1000 | 200,000 |
| 8 | Хөнгөн зууш | 200 | 2000 | 400,000 |
| 9 | Кофе | 200 | 300 | 60,000 |
| | Нийт | | | 2,720,000 |

-oOo-